



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

6
АНГИ

ДИЗАЙН ТЕХНОЛОГИ

ЭРЭГТЭЙ

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:


Сурагчийн нэр:

Сурагчийн код:


САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад хийж гүйцэтгээрэй.
- Зөв гэж үзсэн нэг хариуг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Тойргийн тэнхлэгийг аль зураасаар зурах вэ?



2. Германы мерседес бенз машины логог тойрог тэнцүү хуваах аргаар зохион бүтээсэн байдаг. Тус машины логог зурсан байгуулалтын аргыг сонгоно уу.



3. Дараах дизайны төрлүүдийг зурагтай нь зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу.



1. Хувцасны дизайн
3. Үйлдвэрлэлийн дизайн

2. Архитектур дизайн
4. Чимэглэлийн дизайн






- A. 1-d, 2-b, 3-c, 4-a B. 1-b, 2-a, 3-d, 4-c C. 1-c, 2-a, 3-b, 4-d D. 1-d, 2-a, 3-c, 4-b


4. Дизайны төрлүүдээс чимэглэлийн дизайныг сонгоно уу.



5. Дараах дүрсүүдээс зөв 8 өнцөгт зохиомжийг сонгоно уу.



6. Зураасны стандартын дагуу зөв зурсан тойргийг сонгоно уу.



7. Модлогуудын ерөнхий ангиллыг сонгоно уу.

- A. хатуу ба зөөлөн
B. нягт ба сийрэг
C. шилмүүст ба навчит
D. хар ба бусад

8. Нарс модны онцлог шинж чанарыг сонгоно уу.

- A. Хээ зураглал нь бүдэг, улаавтар өнгөтэй, зөөлөн мод, хийсэн эдлэл нь хөнгөн болдог.
B. Тод өнгөтэй, гоёмсог хээ зураглалтай, хатуу мод.
C. Зөөлөн, нягт ширхэгтэй, шаргал цагаан өнгөтэй, сийлбэр хийхэд тохиромжтой мод.
D. Зөөлөн, хөнгөн, урт удаан хугацааны туршид цагаан өнгөө хадгалдаг мод.

9. Гэрийн тооно, уурга, хувин, сүх, алхны иш, аяга, зэлийн гадас, тавилга, эмээлийн мод зэргийг хийхэд хамгийн тохиромжтой модыг сонгоно уу.

- A. нарс
B. хус
C. хуш
D. улиас

10. Модны чийг шингээх үзэгдэлд нөлөөлөх физик шинж чанар юу вэ?


- A. нягт
B. хээ зураглал
C. дуу авиа дамжуулалт
D. гялалзалт

11. Морин хуур, цохилуур хөгжим, төрөл бүрийн амьтдын дуу авиа гаргах хүүхдийн тоглоом хийхэд модны ямар шинж чанар чухал байдаг вэ?



- A. хатуу, зөөлөн
B. нягт, сийрэг
C. өнгө, гялалзалт
D. дуу авиа дамжуулах

12. Зурагт үзүүлсэн шувууны үүр хийхэд мод боловсруулах ямар технологиудыг зөв дараалуулан ашигласан бэ?



- A. наах, тууш зүсэх, огтлох, нүхлэх,
B. тууш зүсэх, наах, огтлох, өнгөлөх
C. огтлох, хадах, чимэглэх, өнгөлөх
D. углуурга холболт, огтлох, өнгөлөх

13. XIV зууны дунд үед төмрийн хүдэр хайлах жижиг зуух зохион бүтээж ширэм, болдыг гарган авсан ба төмрийн дархчид зэвсэг, ахуйн хэрэглээний эд зүйлс, хадаас, дугуйны мөр, морины тах зэргийг олноор хийж байжээ. 1890-ээд оноос техник, гүүр, барилгын хийцэд хөгжил авчирсан металлыг сонгоно уу.

- A. хөнгөн цагаан
B. цагаан тугалга
C. хар тугалга
D. ширэм

14. Металлыг хар ба өнгөт, ховор ба үнэт гэж ангилдаг. Өнгөт металлыг сонгоно уу.

- A. алт, мөнгө
B. вольфрам, уран
C. төмөр, ширэм, болд
D. зэс, цайр, хар ба цагаан тугалга


15. Цэвэр төмөр нь зөөлөн, уян налархай металл байдаг бол хэдэн хэмд хайлдаг вэ?

- A. 961°C
B. 1539°C
C. 660°C
D. 1085°C

16. Төмрийн хүдрийг домен зууханд хайлуулж, ширэм, ширмийг дахин хайлуулж болд гарган авдаг. Болдыг хийцийн, багажийн, нүүрстөрөгчит чанаржуулсан, тусгай найрлагатай гэж ангилдаг. Хийцийн болдыг сонгоно уу.

- A. төрөл бүрийн техникийн араа, гол, нум
B. гар хөрөө, харуулын ир, төмрийн хөрөө, цүүц
C. хуудсан хар металл, төмөр утас, булан төмөр
D. алх, бахь, түлхүүр, төмрийн хайч, хасуур

17. Зурагт металл боловсруулах ямар технологийг харуулсан бэ? Зөв хариуг сонгоно уу.



- A. төмөр утас таслах
B. төмөр утас матах
C. төмөр утас цувих
D. төмөр утас эмхэрдэх

18. Зурагт үзүүлсэн төмөр утсан тоглоомыг хийх зөв технологиудыг сонгоно уу.




- A. таслах, өнгөлөх, давтах, эмхэрдэх
B. өнгөлөх, тэгшлэх, нугалах, таслах
C. тэгшлэх, өнгөлөх, нугалах, эмхэрдэх
D. таслах, чимэглэх, өнгөлөх, нугалах

19. Унадаг дугуйны урд дугуйг яагаад том хэмжээтэй хийдэг байсан бэ?



- A. тэнцвэртэй болгох
B. гоёмсог болгох
C. хөнгөн болгох
D. хурдан явдаг болгох

20. Нударган механизм ашиглан хийсэн “Дэгдээхэй” хөдөлгөөнт тоглоомын өндөгний хальсыг алгуурхан нээгдээд огцом хаагдах үйлдэл хийхийн тулд аль нударган механизмыг ашиглах вэ?



A



B



C



D